




ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-нд хийсэн нийцлийн
аудитын тайлан
/ҮАГ-НАГ/2018/01-НА/



Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

2018 он

АГУУЛГА

	Товчилсон үгс	4
	График болон хүснэгтэн мэдээллийн жагсаалт	4
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үндсэн мэдээлэл	5-7
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Бүлэг 1. Хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж хуульд заасан мэдээллийг мэдээллийн самбарт мэдээлсэн боловч цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй байна.	
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан боловч хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.	8-10
Аудитын менежер Х.Наранцацрал	1.2 Хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг байгууллагын самбарт мэдээлж байна.	10-11
Ахлах аудитор Д.Ихбаяр	Бүлэг 2. Хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.	
Аудитор Д.Должинсүрэн	2.2 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд хамрагдаж, мэдээллээ оруулаагүй байна.	11
	2.3 Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд хамрагдаж, мэдээллээ оруулаагүй байна.	11-12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.	
Уг тайланг ҮАГ-ын вэб хуудаснаас үзнэ үү. www.audit.mn	3.1 Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	12
Хаяг: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар	3.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны үйл ажиллагаанд тавьсан хяналт дуусаагүй байна.	12
	3.3 Шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцахгүй байна.	12-13
2018 оны 11 дүгээр сар	3.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	
	Дүгнэлт	14
	Зөвлөмж	15

	Дээд байгууллагад хүргүүлэх санал	16
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар, аудитын газрын тайлбар	17
	Тайланг баталгаажуулсан тушаал	18
	Тайлангийн хавсралтууд	19-29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Товчилсон үгийн тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНТБ	Орон нутгийн төсөвт байгууллага
УТБ	Улсын төсөвт байгууллага
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага

ГРАФИК БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Төсвийн байгууллагын судалгаа
Хүснэгт №2	Хуулийн 3.1.4-т хамаарах байгууллагын судалгаа
График 1	7 хоногийн дотор тайлагнах мэдээлэл /төсөв, хөрөнгөтэй холбоотой/
График 2	Тогтмол хугацаанд мэдээлэх мэдээллийг шилэн дансанд байршуулсан байдал
Хавсралт 1	Дундговь аймгийн хэмжээнд шилэн дансанд бүртгүүлэх байгууллагын судалгаа
Хавсралт 2	Хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагуудын тоо, санхүүжилтийн судалгаа
Хавсралт 3	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа
Хавсралт 4	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн судалгаа
Хавсралт 5	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын "долоо хоног"-ийн дотор мэдээлэх мэдээллийг байршуулсан судалгаа
Хавсралт 6	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар "тогтсон хугацаа"-д мэдээлэл байршуулсан судалгаа
Хавсралт 7	Аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн байгууллагын судалгаа
Хавсралт 8	Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байгууллагын судалгаа
Хавсралт 9	ТЕЗ нарын шилэн дансны цахим хуудаст мэдээлэл оруулсан байдал

АУДИТЫН НЭР: “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”**АУДИТЫН КОД: ҮАГ-НАГ/2018/01-НА****АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг хийлээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

ДЭД ЗОРИЛТ

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4,⁴ 3.1.5⁵-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитын асуудлын шинжилгээнд орсон орон нутагт хамааралгүй дараах асуудлуудыг тайланд тусгаагүй болно. Үүнд:

- 1 дүгээр бүлгийн А.3;
- 2 дугаар бүлгийн Б.1.

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² Төрийн өмчит үйлдвэрийн газрууд

³ Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд

⁴ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд

⁵ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Дундговь аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу хамрагдвал зохих нийт 267 байгууллагаас 178 байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байна.

Аудитад Дэрэн, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Хулд, Луус, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан сум зэрэг нийт 11 сум болон аймгийн ТЕЗ-ийн 12, улсын болон орон нутгийн төсвийн 113, ЗГТС 3, ОНӨААТҮГ 14 нийт 142 байгууллагын 2017 оны 4 дүгээр улирал, 2018 оны эхний 3 дугаар улирлын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулсан мэдээллийг батлагдсан төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээнүүд, эрх бүхий албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, НББ-ийн журнал, холбогдох баримтыг хамруулан тулгалт хийж, шалгасан. Үлдсэн 4 сумын ТЕЗ-ийн 4, улсын болон орон нутгийн төсвийн 24, ОНӨААТҮГ 5 нийт 33 байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулсан эсэхийг судалгааны түвшинд шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Нийцлийн аудитын түр журмыг ашиглан, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс цуглуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа хийх;
- Цуглуулсан мэдээ судалгаанд харьцуулалт, нөхцөл байдлын шинжилгээ хийх;
- Аудитад хамрагдсан байгууллагуудын шилэн дансны нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, тушаал, шийдвэр, мөнгөн гүйлгээний журналтай тулгах.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглааа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;

- Шилэн дансны тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

АУДИТЫН ХУГАЦАА, БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2018 оны 10 дугаар сарын 18 –ны өдрөөс эхлэн 11 дугаар сарын 28-ний өдрийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ДҮН

Аудитаар нийт 83 байгууллагад 5,381.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 33 байгууллагын 455.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 32 байгууллагын 1,365.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 33 байгууллагын 3,560.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, 1 байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүллээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор анх баталж, шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулж эхэлсэн. 2016 оны эхээр шилэн дансны цахим сайт шинэчлэгдэн өмнөх журмыг хүчингүй болгож, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг хийж, аудитаар 15,285.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 735.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн байна. Мөн аймаг, сумдын Засаг дарга нарт 4 заалт бүхий зөвлөмж, ҮАГ-аар дамжуулан Сангийн яаманд 3 саналыг хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 1. Хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж хуульд заасан мэдээллийг мэдээллийн самбарт мэдээлсэн боловч цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй байна.

1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан боловч хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Дундговь аймгийн хэмжээд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1⁶–дэх хэсэгт хамаарах 267 байгууллага байна. /Хавсралт №1/

Хүснэгт №1 Төсвийн байгууллагын судалгаа

Хуулийн заалт	Өмчийн хэлбэр		Нийт байгууллагын тоо	Шилэн дансны сайтад бүртгэлтэй
3.1.1.⁷	ОНТБ	ТЕЗ	16	16
		ТШЗ	113	113
	УТБ	ТШЗ	26	25
		ЗГТС	3	3
	ОНӨААТҮГ		19	19
3.1.2.⁸	ТӨҮГ		8	2
	Нийт		185	178

Тус хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах нийт 185 байгууллагаас 178 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 /Төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай

холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй/ -т заасны дагуу Тагнуулын ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь хэлтэс шилэн дансанд бүртгэлгүй байна.

Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа 8 ТӨҮГ-аас Зам тээврийн яамны харьяа Нисэх буудал, Авто тээврийн үндэсний төвүүд нь шилэн дансны цахим хуудастай, бусад ТӨҮГ-уудын шилэн дансыг төв компани нь өөрийн шилэн дансны цахим хуудсанд нэгтгэн мэдээлжээ.

Орон нутагт салбартай төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувьцаат компаниуд нь шилэн дансны цахим хуудсанд салбар байгууллага тус бүрээр эсвэл нэгтгэж мэдээлэх эсэх талаар Шилэн дансны тухай хуульд тодорхой заагаагүй. Энэ асуудлыг цаашид журмаар зохицуулан тодорхой болгох талаар өмнөх аудитуудаар удаа дараа ҮАГ-аар дамжуулан санал хүргүүлсэн боловч тодорхойгүй хэвээр байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй 178 байгууллагын шилэн дансны цахим хуудас дахь мэдээллийг тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Тухайн мэдээлэл гарснаас хойш "долоо хоног"-ийн дотор цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээллийг тулган шалгахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтаар нийт 1042 удаагийн гүйлгээгээр 5,269.5 сая төгрөгийн гүйлгээ хийснээс 894 удаагийн гүйлгээгээр 5,022.1 сая төгрөгийн гүйлгээ хийснийг мэдээлж, хэрэгжилт 95.3 хувь;

⁶ 3.1. Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

⁷ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

⁸ Төрийн өмчит үйлдвэрийн газрууд

- ✓ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг нийт 685 удаагийн гүйлгээгээр 26,564.9 сая төгрөгийн гүйлгээ хийснийг мэдээлэхээс 629 удаагийн гүйлгээгээр 25,720.6 сая төгрөгийн гүйлгээ хийснийг мэдээлж, хэрэгжилт 96.8 хувь;
- ✓ Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээгээр нийт 98 удаагийн гүйлгээгээр 1,872.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлэхээс 85 удаагийн гүйлгээгээр 1,738.3 сая төгрөгийн гүйлгээг хийснийг мэдээлж, хэрэгжилт 92.8 хувь;
- ✓ Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллээр нийт 1,988 ширхэг 5,010.3 сая төгрөгийн тушаал, шийдвэр мэдээлэхээс 1,183 ширхэг 2,689.0 сая төгрөгийн тушаал, шийдвэрийг мэдээлж, хэрэгжилт 53.7 хувьтай байна. / Хавсралт №3, График №1/



Харин хуулийн дагуу тогтмол хугацаанд мэдээлэхээр заасан мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн эсэхийг шалгахад тухай бүр, сар бүр буюу байнга мэдээлдэг мэдээллийг 90.8-95.4 хувь буюу 156-168 байгууллагууд тогтмол мэдээлж байна.

График №2—аас харахад жилд нэг удаа мэдээлэх тухайн жилийн батлагдсан төсөв, санхүүгийн тайлан /хагас, бүтэн жил/, аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг 80.6-87.6 хувь буюу 140-155 байгууллага мэдээлсэн байна. Хамгийн бага 46.1 хувь буюу 82 байгууллага төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг хуулийн дагуу мэдээлсэн. Харин бусад байгууллагын хувьд төсвийн гүйцэтгэлийн тайланг мэдээлэхдээ нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын гүйцэтгэлийг төсвийн үлдэгдэл хэтрэлттэй харагдана гэсэн шалтгаанаар мэдээлэхгүй байна. Энэ нь хариуцсан албан тушаалтнууд төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг оруулахгүй, ажилдаа хариуцлагагүй хандаж байгаатай холбоотой байна.

График №2 Тогтмол хугацаанд мэдээлэх мэдээллийг шилэн дансанд байршуулсан байдал



Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургууль, 7-р цэцэрлэг зэрэг төсвийн байгууллагууд шилэн дансны цахим хуудас дахь мэдээллийг хуулийн дагуу бүрэн мэдээлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг 16 ТЕЗ шилэн дансны цахим хуудсаараа дамжуулан мэдээлэхээс 12 сумын ТЕЗ хугацаандаа мэдээлж, аймгийн ТЕЗ болон Дэрэн, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумын ТЕЗ огт мэдээлээгүй байна. /Хавсралт №3/

Аудитаар 83 байгууллагад 3,092.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 17 байгууллагын 671.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 32 байгууллагын 1,365.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, өмнөх аудитаар зөвлөмж өгөгдсөн 33 байгууллагын 1,094.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангаагүй Сайхан-Овоо сумын Эмийн эргэлтийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга буюу сумын Засаг дарга нарт хариуцлага тооцох санал хүргүүлээ. /Хавсралт № 7,8/

Өмнөх онуудад Төрийн аудитын газраас 4 удаа, Санхүүгийн хяналт, аудитын албанаас 1 удаа Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийгдсэн боловч зөрчил давтагдсаар байгаа нь байгууллагын удирдлага болон нягтлан бодогч нарын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна. Иймд ТЕЗ ажлын хариуцлага алдсан албан тушаалтнуудад арга хэмжээ авч, зөрчлийг давтан гаргуулахгүй ажиллах шаардлагатай байна.

Мөн дараа жилийн төсвийн төслөө 69.5 хувь буюу 98 байгууллага хугацаандаа, 25 байгууллага хугацаа хоцроож мэдээлснээс сумдын ТЕЗ болон ОНӨААТҮГ-ууд мэдээлээгүй, зарим сумын ТЕЗ нар харьяа төсвийн байгууллагуудын дараа жилийн төсвийн төслийг давхар мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1. /аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;/ 8.5.3.-дахь /сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;/ заалтууд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3.-дахь /дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;/ заалттай зөрчилдөж байгаагаас шалтгаалсан байна. Иймд сумдын ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудаснаас дараа жилийн төсвийн төсөл оруулах цэсийг хасуулах саналтай байна.

1.2 Хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг байгууллагын самбарт мэдээлж байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8⁹ дахь хэсэгт заасны дагуу төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийн самбарыг ашиглан олон нийтэд мэдээллийг хүргэж байна.

Өмнөх аудитаар зарим байгууллагуудын хувьд шилэн дансны мэдээллийн самбарыг нягтлан бодогчийн өрөөнд байрлуулсан, мэдээллийг шинэчлээгүй зэрэг зөрчил илэрсний дагуу зөвлөмж өгөгдсөн байна. Аудитын явцад зарим

⁹ 5.8.Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

байгууллагын шилэн дансны самбарыг шалгахад зөвлөмжийн дагуу шилэн дансны самбарыг олон нийт чөлөөтэй танилцах боломжийг хангасан газарт байрлуулсан байна.

БҮЛЭГ 2. Хуулийн 3.1.4 болон 3.1.5 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.

2.2 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд хамрагдаагүй, мэдээлэл оруулаагүй байна.

Аудитын хамарсан хугацаанд аймгийн хэмжээгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 53 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээнд 49 аж ахуйн нэгж, байгууллага шалгарч, 1,813.4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. /Хавсралт № 2,3/

Хүснэгт №2 3.1.4 хамаарах байгууллагын судалгаа

Хуулийн заалт	Санхүүжилт өгсөн	Өмчийн хэлбэр	Нийт байгууллагын тоо	Төсөл хөтөлбөр	Шилэн дансны сайтад бүртгэлтэй	
3.1.4.	УТХО	ААНБ	12	13	0	
	ОНХС	ААНБ	15	17	0	
	ОНХО	ААНБ	20	20	0	
		Хороо		1	1	0
		ОНӨААТҮГ		1	2	1
	Нийт		49	53	1	

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.4 дахь заалтад хамаарах нийт 49 ААНБ-аас Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-аас

бусад аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны цахим хуудас нээлгээгүй байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2 арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулж, орон нутгийн хөрөнгө оруулалтаас 11.4 сая төгрөгийн санхүүжилт авснаас шилэн дансны цахим хуудастаа 9.8 сая төгрөгийн үйл ажиллагааг мэдээлсэн байна.

2.3 Шилэн дансны тухай хуулийн 3.1.5 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.5 дахь заалтад хамаарах нийт 38 ААНБ үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Малын вакцины тарилгын үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж, 631.5 сая төгрөгийн санхүүжилт авсан сумдын 35 мал эмнэлэг;
- Улсын төсвөөс 198.6 сая төгрөгийн санхүүжилт авсан 2 нөхөрлөл /Өрхийн эмнэлэг/;
- Орон нутгийн төсвөөс 30.6 сая төгрөгийн санхүүжилт авсан Ахмадын хороо. /Хавсралт № 2,4/

Боржигон мандал, Өлзийт мандал өрхийн эмнэлгүүдээс бусад байгууллагууд шилэн дансны цахим хуудас нээлгээгүй, мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер шалгаруулах болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу мэдээллийг оруулах талаар гэрээнд тусгаж, гэрээг дүгнэхдээ мэдээлэл оруулсан байдалд хяналт тавьж ажиллах тухай 2017 онд “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитаар аймаг болон сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байна. Иймд өмнөх аудитаар өгөгдсөн

зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай хугацаатай 2,465.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

БҮЛЭГ 3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

3.1 Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 /Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ/ дэх хэсэгт заасны дагуу Төрийн аудитын газар 2018 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар “Аймаг, сумын ИТХ, иргэдийн Нийтийн Хуралд, хуульд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах” талаар албан шаардлага хүргүүлсэн бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2/135 дугаар албан бичгээр 2018 оны 4 улиралд шалгалт хийхээр төлөвлөгөө гаргасан талаар мэдэгдсэн.

3.2 Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн хяналтын дүн гараагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т /Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ./ заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн 2018 оны хэрэгжилтэд 2018 оны 10 дугаар сараас аудит гүйцэтгэж байгаа тул эцсийн хариу гараагүй байна гэсэн хариу өгсөн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн 2018 оны хэрэгжилтэд 2018 оны 10-11 дүгээр сард аудитыг хийж гүйцэтгэсэн нь ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа аудиттай давхцаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж чадаагүй байна. Цаашид дотоод аудитыг оны эхэнд урьдчилан сэргийлэх зорилгоор хийх нь үр дүнтэй байхаар байна.

3.3 Шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцахгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст аймаг, сумдын ТЕЗ нарын байршуулсан мэдээлэл харилцан адилгүй байна. Жишээ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээлэх цэс: Адаацаг, Баянжаргалан, Дэрэн, Сайхан-Овоо, Эрдэнэдалай

сумд нэгтгэсэн сарын төсвийн гүйцэтгэлийг зардал бүрээр дэлгэрэнгүй мэдээлсэн бол аймаг, Өндөршил сумын ТЕЗ нар төсвийн байгууллагуудыг жагсаан, зөвхөн тухайн төсвийн нийт дүнг мэдээлсэн байна. Харин Дэлгэрхангай сум бүх төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр дэлгэрэнгүй мэдээлсэн бол Гурвансайхан, Өлзийт сумд хоосон хадгалж, Цагаандэлгэр сум огт мэдээлээгүй байна.

2. *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) цэс:* Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн сумд төсвийн гүйцэтгэлийн тайлантайгаа ижил мэдээлсэн бол аймаг, Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Хулд сумд огт мэдээлээгүй, Баянжаргалан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумд тайлбар бичсэн байна. Харин бусад сумд сумын төсвийн гүйцэтгэлийн мэдээг бүлгийн дүнгээр, дэлгэрэнгүй байдлаар, байгууллага тус бүрээр зэрэг харилцан адилгүй мэдээлсэн байна. /Хавсралт №9/

3. ОНХС-гийн худалдан авалт, тендертэй холбоотой бүх үйл ажиллагааг сумын ТЕЗ явуулдаг. Гэтэл хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл мэдээлэх (Тухай бүр) цэсийг бүх сум огт мэдээлээгүй байна.

Дээрх байдлаас харахад шилэн дансны мэдээлэл оруулах төсвийн эрх бүхий албан тушаалтнууд шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэст тавих мэдээллийн талаар нэгдсэн нэг ойлголттой болоогүй байна.

Иймд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэст тавих мэдээллийг ямар цэст, ямар мэдээллийг ямар хэлбэр, хүснэгтээр оруулах талаар нэгдсэн чиглэл өгөх шаардлагатай байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцаж уг мэдээлэлтэй холбоотой санал гомдол гаргасан эсэхийг судлахад төрийн аудитын байгууллага болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол, мэдээлэл огт ирүүлээгүй байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ байршуулаагүй, байршуулсан мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй байхад иргэд олон нийтээс өргөдөл гомдол огт ирээгүй байгаа нь иргэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас мэдээлэл авахгүй байгааг харуулж байна.

Иймд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулж буй мэдээллийн агуулгыг зорилтот бүлэг буюу иргэд олон нийтэд ойлгомжтой байдлаар өөрчлөн, хуулийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, иргэдийн хяналт тавих эрхийг таниулах шаардлагатай байна.

Өмнөх аудитаар дээд шатны байгууллагад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зочилсон иргэдийн хандалтын тоог харуулах автомат цонхтой болгох саналыг хүргүүлсэн боловч одоогоор тухайн хуудаст хэдэн иргэд хандаж мэдээлэл авсан болохыг хянах боломжгүй хэвээр байна.

Байгууллагуудын тодруулга өгөх албан тушаалтан солигдож, нэр, холбоо барих утсыг шилэн дансны мэдээлэл тавих эрхээр сольсон боловч, иргэдийн танилцах шилэн дансны нэгдсэн сайтад солигдоогүй байна. Иймд дээрх асуудлыг холбогдох газарт уламжлан, шалтгааныг тодруулж, шийдвэрлэх шаардлагатай байна.

3.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар аймаг, сумдын Засаг дарга нарт дараах 4 зөвлөмжийг өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад хангалтгүй байна. Үүнд:

1. “Зөрчлийг давтан гаргаж байгаа албан тушаалтнуудад арга хэмжээ авч, 14,549.9 сая төгрөгийн зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах” гэсэн зөвлөмж өгсний дагуу аймгийн Засаг дарга 4 сумын Засаг дарга, төсвийн болон ОНӨӨААТҮГ-уудын 3 албан тушаалтанд арга хэмжээ тооцон зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж байгаа тухай хариуг өгсөн боловч 2018 оны аудитаар албан тушаалтнууд өмнөх жилд гаргасан зөрчил дутагдлаа арилгаагүй байна.
2. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер шалгаруулах болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу мэдээллийг оруулах талаар гэрээнд тусгаж, гэрээг дүгнэхдээ мэдээлэл оруулсан байдалд хяналт тавьж ажиллах” гэсэн зөвлөмж өгсөн боловч аудитаар шалгахад зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил арилаагүй байна.
3. “Хуулийн дагуу ил, тод байдлыг хангуулж, тус хуулийг иргэдэд сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн зөвлөмж өгсний дагуу “Хуулийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянаж байна.” гэсэн хариу ирүүлсэн боловч хууль сурталчилсан талаарх нотлох баримт байхгүй, аймгийн хэмжээнд хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.
4. “Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу байгууллагууд шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудас /Dundgovi.gov.mn/-д байршуулах ажлыг зохион байгуулах” гэсэн зөвлөмжийн дагуу Говь-Угтаал, Өндөршил сумдын шилэн дансны цэсийг Dundgovi.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна.

Аймаг, сумын төсвийн захирагч нар аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг хугацаанд нь хүргүүлж байгаа боловч хэрэгжилтийг дараагийн аудитаар шалгахад илэрсэн зөрчил арилаагүй давтагдан гарсаар байгаа нь зөвлөмжийг хэрэгжүүлэх ажилд ач холбогдол өгдөггүй, зөрчлийг арилгасан гэсэн худал мэдээллийг төрийн аудитын байгууллагад өгч байгаатай холбоотой байна.

Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 15.1.2 /Хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн;/ -дахь заалтыг зөрчиж байгаа бөгөөд цаашид дээрх зөрчлийг гаргасан албан тушаалтанд тус заалтаар хариуцлага тооцогдохыг эрх бүхий албан тушаалтнууд анхаарч ажиллах хэрэгтэй.

Иймд Төрийн аудитын байгууллагаас өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон хэрэгжилтийг хангуулж, хариу ирүүлэхдээ нотлох зүйлийн хамт ирүүлж байх шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6. –д /Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй/ заасны дагуу албан шаардлагыг хүргүүллээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт өгч байна. Үүнд:

1. Хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж хуульд заасан мэдээллийг мэдээллийн самбарт мэдээлсэн боловч цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй байна.
2. Хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.
3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
4. Шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцахгүй байна.
5. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

